

## ТАЙВАНИЙ “ХААНЫ ОРДОН” МУЗЕЙД МОНГОЛЫН СУДАЛГААНЫ БАГ АЖИЛЛАНА

Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Д.Рэгдэл, Тайваний Гадаад хэргийн дэд сайд, ноён Чин Шань Хоу нарын 2016 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан уулзалт, Монгол Улсын ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн доктор Н.Ганбат, Тайваний “Хааны ордон” музейн захирал, ноён Лин Жен И нарын 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Тайбей дэх ажлын уулзалтын хүрээнд хоёр талын найрсаг, үр ашигтай хамтын ажиллагааг бий болгон хөгжүүлэх хүсэл сонирхолын дагуу Монгол Улсын ШУА, Тайваний “Хааны ордон” музей, Тайбей дэх Улаанбаатарын худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газар хамтран Харилцан ойлголцлын Санамж бичгийг байгуулахаар ажиллаж байна. Санамж бичгийг 2017 оны 7 дугаар сард Тайваньд гарын үсэг зурж баталгаажуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Тайваний “Хааны ордон” музейд хадгалагдаж буй Монголын түүхийн дурсгалуудыг хамтран судалж, Монгол улс болон Тайваны олон нийтэд танилцуулах, гадаад ертөнцөд сурталчлах, монголын түүхэнд холбоотой эртний эдлэл, уран зураг, уран бичлэгийн дурсгалууд, ховор ном, түүхийн баримт бичгүүд, Тайваний “Хааны ордон” музейн цуглуулгад холбогдох Монголд буй түүх, соёлын эд өлгийн зүйлс, археологийн түшиц газруудын судалгааны чиглэлээр харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, хамтран ажиллах юм.

Тайваний “Хааны ордон” музейд ажиллах судалгааны багийг Монгол улсын ШУА бүрдүүлэх бөгөөд

**1. 2017-2018 онд ажиллах Судалгааны баг:** Удирдагч: ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D), профессор С.Чулуун, судлаачид: доктор (Ph.D), дэд профессор Н.Ганбат, Тайвань дахь Улаанбаатар хотын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны төлөөлөгчийн газрын төлөөлөгч, доктор (Ph.D) Я.Ганбаатар, ТАХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г.Батцоож, эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г.Одмагнай)

**2. 2019-2020 онд ажиллах Судалгааны баг:** Удирдагч: ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), дэд профессор Н.Ганбат, Дундад зууны Монголын түүхийн судалгааны салбарын эрхлэгч доктор (Ph.D) Ц.Цэрэндорж, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), дэд профессор А.Пунсаг, Тайвань дахь Улаанбаатар хотын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны төлөөлөгчийн газрын төлөөлөгч, доктор (Ph.D) Я.Ганбаатар, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Дорно дахин судлалын тэнхмийн багш, доктор (Ph.D), профессор В.Батмаа, доктор (Ph.D) Гэрэлчулуун ба бусад)-ийг тус тус бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, улиралд 2-3 сарын хугацаатай ажиллуулахаар төлөвлөж байна. Тайваньд хадгалагдаж буй Монголын түүхэнд холбогдох манж, монгол, хятад хэлээрх үндсэн сурвалжтай танилцан судалж, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулахаар ажиллаж байгааг дуулгахад таатай байна.

*Шинжлэх ухааны Академи  
Д.Энх-Амгалан*